



Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл

Урлалын Политехник Коллеж

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

Сэдэв: МСҮТ-д элсэн суралцаж буй суралцагчдын хандлага төлөвшлийн байдлыг илрүүлэх нь

Илтгэгч: ..... / Б.Эрдэнэчимэг /

Улаанбаатар хот

2019 он

## **Агуулга:**

Нэгдүгээр хэсэг.

1. Оршил

1.1 Зорилго

1.2 Зорилт

1.3 Судлах зүйл

1.4 Судалгааны арга

1.5 Судалгааны ажлын шинэлэг тал

Хоёрдугаар хэсэг. Онол

2.1 Хүүхэд гэж хэн бэ?

2.2 Хүүхдийн хөгжил, төлөвшил

Гуравдугаар хэсэг. Судалгааны ажил

3.1 Судалгааны хэсэг

Дүгнэлт

Ашигласан материал

## 1. Оршил

“Улсын сайн хүнээсээ

Хүний сайн хүүхдээсээ” Үнэхээр сайн улс болъё гэвэл хүүхдээ зөв, сайн хүмүүжил төлөвшилтэй болгох хэрэгтэй хэмээн Монгол улсын ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж хэлсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газар, БШУ-ны яам боловсролын чанарын асуудалд онцгой анхаарч өөрчлөлт шинэчлэлт хийсээр байгаа билээ. Энэ шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй өөрчлөлтийн нэг хэсэг нь хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилго юм. Хүүхэд бүрийг хөгжүүлэх нь багш нарын сэтгэл, зүтгэл, хичээл төлөвлөлт, заах арга зүй ур чадвартай салшгүй холбоотой.

**1.1. Зорилго:** МСҮТ-д суралцаж буй суралцагчдын хандалага төлөвшлийн байдлыг илрүүлэх

### 1.2. Зорилт:

- Хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар онолын холбогдох ном зохиол, уншиж судлах
- Хүүхдийн хүмүүжлийн өөрчлөлт практик ба сурах үйл ажиллагаандаа хэрхэн нөлөөлж байгаа талаар суралцагчдаас судалгаа авч түүнд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах

**1.3. Судлах зүйл:** Суралцагчдын хөгжил, төлөвшил өөрчлөгдсөнөөр хичээлийн идэвхи оролцоо, сонирхол буурахад хэрхэн нөлөөлж байна вэ? Хүүхдийн хөгжил, төлөвшилд ямар хүндрэлтэй асуудал байна вэ? Түүнээс зайлсхийх арга замыг судлаж цаашид анхаарах ба хэрэгжүүлэх боломжтой асуудлыг олж илрүүлэх

**1.4. Судалгааны арга:** Тестийн арга, ажиглалтын арга, ном зохиол судлах, интернэтээс мэдээлэл хайх, математик боловсруулалт, нэгтгэн дүгнэж дүн шинжилгээ хийх.

**1.5. Судалгааны ажлын шинэлэг тал:** Монгол улсын засгийн газар боловсролын салбарт шинэчлэлт хийх бодлого явуулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн. Үүнтэй холбоотой хүүхэд бүрийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт багш бидний өмнө гарч ирсэн бөгөөд сургалтын чанар үр өгөөж бүтээмжийг тасралтгүй дээшлүүлэхийн тулд багш өөрийгөө хөгжүүлж өөрийн шавь нараа хөгжилрүү хөтлөх хэрэгтэй болсон. Сайн шавь төрүүлж гаргахад зөвхөн багшаас дан ганц хамаарах асуудал биш юм. Улс орны хөгжил, цэцэглэлт түүнийг дагаад мэдээллийн технологийн хөгжил хүүхдийн сурган хүмүүжүүлэх их үйлсэд саад болохоос гадна бие хүний хөгжил төлөвшилд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Мэдээллийн технологийн хөгжилрүү хэт туйлшран орж янз бүрийн мэдээ, мэдээллийг авснаар түүнийг даган дуурайх, донтох, бусдын нөлөөнд автах зэргээс болж хүүхэд гэр бүл найз нөхөд, анги хамт олон, багш сурган хүмүүжүүлэгчтэй харилцах харилцаа

жилээс жилд доройтсоор байна. Үүнтэй холбоотой сурагчдын сурлагын амжилт суларч хичээлд оролцох идэвх нь буурч байгаа нь бидний сэтгэл түгшээсэн асуудлын нэг болж байна. Иймээс сурлагын амжилтыг сайжруулахын тулд хүүхэд нэг бүрийн хүмүүжил, үүрэг хариуцлага хамгийн чухал болоод байна.

## 2. Онолын хэсэг

### 2.1. Хүүхэд гэж хэн бэ?

Хүүхэд эцэг эхийнхээ он цагийн үргэлжлэл болж ертөнцөд мэндэлдэг билээ.. Тэгвэл хүүхэд гэж хэн бэ? Асуултанд эрдэмтэд янз бүрээр тодорхойлсон байдаг.

Жишээ нь:

- ❖ 18-аас доош насны хүнийг хүүхэд гэнэ. /НҮБ-ийн хүүхдийн эрхийн конвенц/
- ❖ Хүүхэд нь бие бялдар оюун ухааны хамгийн эрчимтэй өсөлт хөгжилтийн үедээ байгаа хүн
- ❖ Хүүхдийн нийгмийн харилцаанд оролцох чадавхи нь хязгаарлагдмал байдгаараа насанд хүрэгчдээс ялгаатай гэх мэт

Ардчилсан нийгмийн нэг онцлог нь эрх чөлөө, ард иргэдийн эрх юм. Хүн бүр хуулиар олгогдсон эрхээ эдэлж үүргээ биелүүлэх хэрэгтэй. Эрх гэдэг нь эрх олгож тунхаглах эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдөж олгогдсон эрх мэдлийг хэлнэ. Хүүхдийн эрх гэдэг нь хүүхэд гэдэг ойлголтонд хамрагдах нийгмийн хэсгийн сайн сайханд зайлшгүй хэрэгцээтэй онцгой халамж анхаарал авах эрх юм. НҮБ-ийн хүүхдийн эрхийн конвенцид хүүхдийн амьдралыг тодорхойлох 4 үндсэн эрхийг тусгасан байдаг. Үүнд

#### 1. Эсэн мэнд өсөж бойжих:

- Амьдрах
- Нэр авах
- Иргэний харьяалалтай байх
- Бие хүн байх

#### 2. Хөгжих

- Оюун ухаан авьяас билэг, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах
- Яс үндэс, арьс өнгө, хэл, нас хүйс, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлагдахгүй байна.

#### 3. Асарч хамгаалуулах

- Буруутай үйлдлийнхээ учир шалтгааныг тайлбарлах
- Харилцан ойлголцон эрх тэгш байдалд асуудлыг шийдэх
- Хүүхэд өөрөө учрыг нь ойлгох
- Буруу үйлдэлдээ хариуцлага хүлээх

#### 4. Оролцох

- Өөрт зориулагдсан сургалт, эмчилгээ, үйлчилгээ, асрамж сувилалд үнэлгээ өгөх, санал бодлоо илэрхийлэх
- Хамт олон болон нийгмийн амьдралд чөлөөтэй оролцон өөрийгөө хөгжүүлэх, байр сууриа эзлэх, амьдралын орчиноо бий болгох эрхтэй .

#### 2.2. Хүүхдийн хөгжил, төлөвшил

Хүүхдийн хөгжил төлөвшил гэдэг нь бие бялдар, оюун ухаан, ажиллах чадвар, биеэ авч явах байдал, юмс үзэгдэлд хандах хандлага ба харилцаанд чанарын өөрчлөлт гарах үйл явц юм. Хүүхдийн хөгжил төлөвшил нь хоорондоо салшгүй холбоотой асуудал бөгөөд хүүхдийн хөгжил нь бие хүн болон төлөвшихөд чиглэдэг. Амьдралын бүхийл үйл ажиллагааны үр дүн болсон мэдлэг, чадвар, дадал, туршлага, бие хүний хөгжлийн цар хүрээ, түвшин нь хүний ерөнхий соёлыг илэрхийлнэ. Үүнийг төлөвшил гэнэ. Хүүхдийн төлөвшилд дараах хүчин зүйлүүд нөлөөлдөг. Үүнд:

- 1) Удамшлын нөлөө
- 2) Гадаад орчны нөлөө
- 3) Хувь хүн өөрийнх нь хувийн онцлог чанарууд
- 4) Сурган хүмүүжүүлэх зорилготой үйл ажиллагаанууд хамаарна.

Сурган хүмүүжүүлэх ухааны үүднээс авч үзвэл хүүхдэд төлөвших хүмүүжил, төлөвшил нь дараах элементүүдийн нэгдлээр тодорхойлогддог бөгөөд бид эдгээрийг ямагт нэгдмэл үйл ажиллагаагаар тогтмол хэрэгжүүлж, хэвшил болгох шаардлагатай байдаг байна.

1. Оюун ухааны хөгжил төлөвшил: Хүүхдэд шинжлэх ухааны цэгцтэй мэдлэг олгож, тэдний танин мэдэх хэрэгцээ сонирхлыг өрнүүлж, сэтгэн бодох авъяас чадварыг хөгжүүлж, ертөнцийг үзэх үзэл, итгэл төлөвшүүлэх зорилго чиглэлтэй үйл явц, үр дүнгийн нэгдлийг оюун ухааны хөгжил хүмүүжил гэх бөгөөд энэ нь мэдэхүйн чадамжаар төлөвшинө.
2. Хөдөлмөрийн төлөвшил: Хүүхдэд хөдөлмөрт үнэнч шударга зөв хандах, зах зээлийн харилцааны чиг хандлага, хөдөлмөрийн соёлын ерөнхий мэдлэг, чадвар төлөвшүүлэхэд чиглэгдсэн сурган хүмүүжүүлэх үйл явц, үр дүнгийн нэгдлийг хөдөлмөрийн хүмүүжил гэх бөгөөд энэ нь бүтээхүйн чадамжаар төлөвшинө.
3. Ёс суртахууны боловсрол, төлөвшил: Хүн хүнтэйгээ харьцах, хүн төрөлхтний ёс суртахууны үнэт чанарыг эзэмшүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мөрдөх хэм хэмжээ, нормыг ухамсарлуулах, ёс суртахууны өндөр хариуцлагатай үйл ажиллагааг ёс суртахууны боловсрол хүмүүжил гэнэ. Энэ нь оршихуй, нийгэмшихүйн чадамжаар төлөвшигденө.
4. Бие бялдрын хөгжил, төлөвшил: Нийгмийн шаардлагын дагуу хүний бие махбодын зөв хөгжлийг хангах биеийн тамир, спортын мэдлэг эзэмшүүлэх зорилго чиглэл бүхий үйл

явц, үр дүнг бие бялдрын хөгжил, хүмүүжил гэх ба бие бялдрын хүмүүжил нь бүтээхүй, оршихуйн чадамжаар голчлон төлөвшинө.

5. Гоо зүйн боловсрол төлөвшил: Байгаль, урлаг, уран сайхан, хүрээлэн буй амьдралын гоо сайхныг тусган үнэлж, гоо сайхны мэдрэмж, таашаал, ухамсар чадвар, дадал төлөвших үйл явц, үр дүнг гоо зүйн боловсрол гэнэ. Энэ төлөвшилд хөгжим, дүрслэх урлаг, технологийн хичээлийн цогц чадамжууд илүү нөлөө үзүүлнэ.
6. Эрх зүйн боловсрол, төлөвшил: Хүүхдэд хууль эрхийн ухамсар, соёл төлөвшүүлэх зорилго бүхий зохион байгуулалттай үйл явц, үр дүнг эрх зүйн боловсрол хүмүүжил гэнэ.


Хүүхдийн хөгжил, төлөвшилд сургууль, багш нараас гадна тэдний гэр бүл, эцэг, эх, орчин тойрны хүмүүсийн зан чанар, үзэл бодол, үйл хөдлөл маш том байр суурь эзэлдгийг мартаж болохгүй. Иймээс эцэг, эх, сурган хүмүүжүүлэгчид өөрсдөө хүүхдийн өмнө ямагт зөв үлгэр дуурайлалтай, үлгэрлэн дагуулагч байх хэрэгтэй.

### 3. Судалгааны хэсэг

Хамрагдах хүрээ: Судалгааг ҮУПК-ын I-р курсын нийт 163 суралцагчыг хамруулан явуулсан болно.


1. Дунд ангид суралцаж байхад таны сурах сонирхол ямар байсан вэ?

А. их      Б. дунд зэрэг      В. Бага




2.Одоогийн сурлагын тань түвшин дунд ангид сурч байсан сурлагын түвшингээс ямар байна вэ?

А. сайжирсан    Б. хэвийн    В. буурсан




3.Сурлагын түвшин тань буурахад ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?

А. эрүүл мэнд    Б. орчны өөрчлөлт  
В. багшийн арга зүй    Г. анги хамт олон    Д. Эцэг эхийн хараа хяналт буурсан



4. Сурлагын түвшин буурахад ямар сөрөг нөлөөллүүд анх илэрсэн вэ?

1. Сурах идэвх суларсан
2. Уур уцаартай, догшин шүрүүн зантай болсон
3. Гадуур их тэнэх болсон
4. Өөртөө итгэх итгэл буурсан
5. Олон нийтийн ажлаас зайлсхийдэг болсон
6. Эцэг, эх, багшийн шаардлагыг биелүүлэхгүй
7. Хараалын үг хэлэх болсон
8. Гар утасны хэрэглээ





## **Дүгнэлт**

Энэхүү судалгааны ажлаас харахад суралцагчид ахлах ангид буюу МСҮТ-д элсэн орох үед сурах идэвхи буурсан хичээл хийхээс илүү гар утас хэрэглэх, найз нөхөддөө илүү цаг зарцуулж, гадуур дэмий тэнэх сонирхолтой болдог байна. Иймээс сурган хүмүүжүүлэгч бид суралцагчдаа зөв хандлагатай, зөв хүмүүжил төлөвшилтэй хүн болгохын тулд

### **Дэвшүүлж буй санаа:**

1. Хичээлээ төлөвлөхдөө сурагчийн үйл ажиллагаа давамгайлсан хүүхэд төвтэй сургалтыг зохион байгуулах
2. Хүүхдэд байнга урам зориг хайрласан үг хэлэх
3. Хүүхдийн муу талыг хархаасаа илүү сайн талыг харж сайшаан магтах
4. Бусдын хичээлд тогтмол сууж шинэлэг арга барилыг олж түүнийгээ хэрэглэх, турших
- 5.

## **1. Ном зүй**

1. Сургалтын технологи 2002 он
2. Багшийн ном 2014 он
3. Бүтээлч сэтгэлгээний аргууд 2003 он
4. Суралцагчийн сурлагын үнэлгээ 2006 он
5. Интернет мэдээлэл